



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/48/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 261628 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn ЦЭБЭ Консалтинг аудит ХХК захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.2 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага	20
5.3 Албан шаардлага.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ЗТЯ	Зам тээврийн яам
НУБИА ХХК	Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХК	Хувьцаат компани
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инноваци харилцаа холбооны яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот. 15160
Утас: 28 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/667
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 789.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Компанийн нийт авлагын 70.6 хувь буюу 3,815.1 сая төгрөг нь улс хоорондын тооцооны авлага бөгөөд үүнээс 47 харилцагчийн 442.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл, мөн гадаадын 73 байгууллага, дотоодын 35 аж ахуйн нэгж, иргэнд өгөх нийт 238.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Компанийн санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, 2017-2020 онуудад үүссэн, 17 аж ахуйн нэгж байгууллага, 10 иргэнээс авах нийт 67.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй;

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

"Тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал"-ын тендер сонгон шалгаруулалтаар Ард даатгал ХХК-тай 37.0 сая төгрөгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол шуудан ХК-д Төв аймгийн Сэргэлэн сум, Хөшгийн хөндийд хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр баригдсан "Олон улсын шуудангийн илгээмж, ангилан ялгах, гаалийн хяналтад оруулах цогцолбор төв"-ийн 5,358.2 сая төгрөгийн өртөг бүхий 2 давхар барилгын газрыг Зам тээврийн яамнаас 2025 оны "нөхөн төлбөргүйгээр газрыг чөлөөлөх тухай" 03/3346 дугаар бүхий мэдэгдэл мөн Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-иас 2025 оны "Ус дулааныг зогсоох тухай" EG-OA/176 дугаартай албан бичиг ирж 8 дугаар сарын 31-ний өдрөөс ус дулааны хэрэглээг хязгаарласан нь ялган боловсруулах төвийн барилгад эрсдэлтэй нөхцөл үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. А. Ц. НАРАНЧИМЭГ* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,747,302,178.00	8,943,566,851.61
1.1.2	Дансны авлага	5,487,178,266.86	5,410,316,253.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	36,704,950.48	164,421,547.67
1.1.4	Бусад авлага	322,059,493.58	201,982,073.83
1.1.6	Бараа материал	4,417,731,167.56	4,257,717,768.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал / тооцоо	5,529,320,145.79	431,323,802.27
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	25,540,296,202.27	19,409,328,297.39
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,441,368,255.49	13,553,463,732.21
1.2.2	Биет бус хөрөнгө	2,047,471,887.52	2,594,049,775.53
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,489,340,143.01	16,148,013,507.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	37,029,636,345.28	35,557,341,805.13
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,241,178,117.76	8,324,391,133.22
2.1.1.2	Цалингийн өглөг	313,398,175.31	285,490,417.89
2.1.1.3	Татварын өр	14,531,702.64	34,992,892.19
2.1.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	9,467,299.76	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	903,726,893.62	768,509,032.83
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	922,668,661.93	289,248,851.53
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,404,970,851.02	9,702,632,327.66
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,404,970,851.02	9,702,632,327.66
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: – төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2	- хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,714,085,782.53	3,714,085,782.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,033,511,677.43	6,263,555,660.64
2.3.10	Эздийн өмчийн дүн	25,624,665,494.26	25,854,709,477.47
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	37,029,636,345.28	35,557,341,805.13

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	23,894,295,918.89	25,423,475,974.10
2	Борлуулалтын өртөг	21,896,067,590.24	24,540,234,067.30
3	Нийт ашиг (алдагдал)	1,998,228,328.65	883,241,906.80
4	Түрээсийн орлого	164,107,952.36	270,865,888.72
5	Хүүний орлого	333,109,948.54	458,796,129.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,659,968,499.94	1,229,487,235.04
12	Бусад зардал	388,334,496.64	279,123,880.47
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(282,537,488.12)	387,243,593.07
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,999,999.91	26,894,119.15
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	168,605,744.76	518,430,521.95
19	Орлогын татварын зардал	32,587,849.41	45,882,258.59
20	Татварын дараах ашиг (алдагдал)	136,017,895.35	472,548,263.36
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	136,017,895.35	472,548,263.36

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,577,092,385.30	26,168,246,202.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(679,598,603.22)	(679,598,603.22)
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	5,897,493,782.08	25,488,647,598.91
Тайлант үеийн үр дүн					136,017,895.35	136,017,895.35
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,033,511,677.43	25,624,665,494.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(242,504,280.15)	(242,504,280.15)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	5,791,007,397.28	25,382,161,214.11
Тайлант үеийн үр дүн					472,548,263.36	472,548,263.36
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.45	3,379,919,523.85	3,714,085,782.53	6,263,555,660.64	25,854,709,477.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	47,748,533,292.03	44,814,539,396.50
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	19,057,147,706.60	22,678,252,212.93
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,691,385,585.43	22,136,287,183.57
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	51,804,666,064.49	45,499,041,136.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	9,263,002,414.59	10,112,043,395.37
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,600,292,451.72	2,870,220,812.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,116,829,696.22	2,094,119,848.65
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,527,248,679.55	3,595,269,651.78
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,264,220,533.57	3,187,074,513.74
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,569,937,639.86	2,205,769,393.73
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	84,999,772.09	9,725,738.77
1.2.9	Бусад мөнгөн зарлага	25,378,134,876.89	21,424,817,782.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,056,132,772.46)	(684,501,740.30)
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	131,670,064.95	202,555,842.81
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	131,670,064.95	202,555,842.81
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,367,339,065.00	985,382,839.52
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,280,905,165.00	737,948,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	86,433,900.00	247,434,039.52
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,235,669,000.05)	(782,826,996.71)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	586,912,851.70	97,672,829.25
3.2.4	Төлсөн ногдол ашиг	586,912,851.70	97,672,829.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(586,912,851.70)	(97,672,829.25)
4	Гадаад валютын ханшийн зөрүү	(522,533,345.84)	761,266,239.87
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,401,247,970.05)	(803,735,326.39)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,148,550,148.05	9,747,302,178.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,747,302,178.00	8,943,566,851.61

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Гадаад худалдаа	м.төг	9,539,000.0	12,500,000.0	8,122,323.0	(1,416,677.0)	85.1	(4,377,677.0)	65.0
	Дотоод шуудан	м.төг	10,940,000.0	10,740,000.0	12,464,271.3	1,524,271.3	113.9	1,724,271.3	116.1
	Нэмэлт үйлчилгээ	м.төг	3,012,000.0	3,300,000.0	3,760,376.0	748,376.0	124.8	460,376.0	114.0
	Санхүү-салбар	м.төг	1,140,500.0	1,250,000.0	2,150,895.0	1,010,395.0	188.6	900,895.0	172.1
2	Нийт орлого	м.төг	24,631,500.0	27,790,000.0	26,497,865.3	1,866,365.3	107.6	(1,292,134.7)	95.4
3	Нийт зардал	м.төг	23,944,300.0	27,267,500.0	26,050,918.2	2,106,618.2	108.8	(1,216,581.8)	95.5
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	1,660,000.0	2,000,000.0	1,229,457.0	(430,543.0)	74.1	(770,543.0)	61.5
4	Татварын өмнөх ашиг	м.төг	687,200.0	522,500.0	446,947.1	(240,252.9)	65.0	(75,552.9)	85.5
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	136,000.0	470,200.0	407,213.0	271,213.0	299.4	(62,987.0)	86.6
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	4,856,878.0	4,588,750.0	4,562,037.3	(294,840.7)	93.9	(26,712.7)	99.4
	а/ Орлогын татварт	м.төг	48,326.5	32,500.0	32,417.9	(15,908.6)	67.1	(82.1)	99.7
	б/ НӨАТ	м.төг	2,801,395.3	2,250,000.0	2,225,785.7	(575,609.6)	79.5	(24,214.3)	98.9
	в/ НДШ	м.төг	1,934,649.3	2,208,000.0	2,207,774.9	273,125.6	114.1	(225.1)	100.0
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	50,659.4	65,000.0	63,252.1	12,592.6	124.9	(1,747.9)	97.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	4,081.0	4,500.0	4,385.8	304.8	107.5	(114.2)	97.5
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	15,697.9	24,500.0	24,192.4	8,494.5	154.1	(307.6)	98.7
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	2,068.5	4,250.0	4,228.5	2,160.0	204.4	(21.5)	99.5

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	99.8	150.0	149.4	49.6	149.7	(0.6)	99.6
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	961.0	980.0	970.0	9.0	100.9	(10.0)	99.0
9	Нийт цалингийн сан	м.төг	11,287,899.8	12,937,500.0	12,869,700.0	1,581,800.2	114.0	(67,800.0)	99.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	11,746.0	13,201.5	13,267.7	1,521.7	113.0	66.2	100.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.0	1.0	0.0	101.1	0.0	100.2
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,743,300.0	2,622,140.0	1,439,406.9	(303,893.1)	82.6	(1,182,733.1)	54.9
13	Нийт авлага	м.төг	5,845,942.7	5,780,000.0	5,776,719.9	(69,222.8)	98.8	(3,280.1)	99.9
	Үүнээс: Найдваргүй	м.төг	67,783.1	67,800.0	67,783.1	-	100.0	(16.9)	100.0
14	Нийт өглөг	м.төг	11,404,970.9	9,705,000.0	9,702,632.3	(1,702,338.5)	85.1	(2,367.7)	100.0
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	11,404,970.9	9,705,000.0	9,702,632.3	(1,702,338.5)	85.1	(2,367.7)	100.0
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол шуудан ХК нь эрхэм зорилгоо “Дэлхийн дэвшилтэт технологид хүрсэн чанартай цогц үйлчилгээгээр хүн бүрийн шуудангийн хэрэгцээг хангахад оршино” хэмээн тодорхойлж, Монгол Улсад шуудангийн салбарыг хөгжүүлэх, шуудангийн найдвартай ажиллагааг хангах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигт ажиллагааг хангах үндсэн зорилтын хүрээнд ажиллаж байна.

Тус компанийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Захидал, бичиг, боодол, илгээлт зэрэг шуудангийн бүх нийтийн үйлчилгээ;
- Захиалгат илгээмжийн худалдаа;
- Шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, хэвлүүлэх, борлуулах;
- Гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах;
- Шуудангийн тухай хуулиар зохицуулсан бусад үйлчилгээ, үйл ажиллагаа;

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компанийн статустай байна. Өмчийн 66.0 хувийг төр буюу ТӨБЗГ, 14.5 хувийг Ардын тэтгэврийн данс ХХК, 8.0 хувийг Ард санхүүгийн нэгдэл ХК, 5.0 хувийг иргэн Ч.Амарбаатар, 2.4 хувийг Ард кредит ББСБ ХХК, 4.1 хувийг бусад хувьцаа эзэмшигчид тус тус эзэмшиж байна.

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо (ширхэг)	Эзлэх хувь
1	Төр – Засгийн газар	65,727,000	66.0
2	Ард тэтгэврийн данс ХХК	14,411,249	14.5
3	Ард санхүүгийн нэгдэл ХК	7,959,671	8.0
4	Чүлтэмийн Амарбаатар	4,963,756	5.0
5	Ард кредит ББСБ ХХК	2,407,454	2.4
6	Бусад хувьцаа эзэмшигч /3,381/	4,117,223	4.1
Нийт дүн		99,586,363	100.0

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1994 оны 274 дүгээр тушаалаар Монгол шуудан ТӨҮГ болгон өөрчилж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 594 дүгээр тогтоолоор нэмэлт хувьцаа гарган 34.0 хувийг Монголын хөрөнгийн бирж дээр арилжиж Монгол шуудан ХК болгон өөрчилсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтын дагуу компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж томилж байна. Монгол шуудан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ХЭ-25/03 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг томилж, төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн төлөөлөл 4, хараат бус 3, хувийн хэвшлийн төлөөлөл 2, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

ТУЗ нь тайлант хугацаанд 94 хувийн дундаж ирцтэйгээр 13 удаа хуралдаж, 33 асуудлыг хэлэлцэж, 20 тогтоол, 5 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллажээ. ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 24/22 дугаар тогтоолоор компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталж, Марк үнэт цаасны хэлтсийг газар болгож, дотоод аудиторыг ТУЗ-ийн дэргэд ажиллахаар өөрчилсөн байна.

Компани нь хүний нөөц үйл ажиллагаа, санхүү төлөвлөлт, шуудан логистик, бизнес хөгжил, улс хоорондын шуудан, мэдээлэл технологи, салбарын удирдлага, марк үнэт цаасны 8

газар, хяналт шинжилгээ, үнэлгээний болон марк, худалдан авах ажиллагааны 2 хэлтэс, 4 алба, 1 автобааз, 2 төв болон аймаг, дүүргийн шуудангийн салбарууд гэсэн бүтцээр ажиллаж байна.

Мөн үйл ажиллагаандаа Монгол Улсын иргэний тухай хууль, Шуудангийн тухай, Цахим гарын үсгийн тухай хууль, Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нягтлан болох бүртгэлийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо дотоод аудиторыг сонгон шалгаруулах үзүүлэлтийг хэлэлцэж, сонгон шалгаруулалт зарласан боловч томилгоо хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн захирлын 2022 оны А/68 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, компанийн онцлогт тохирсон боловч шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,472.3 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,747,302.2	8,943,566.9	(803,735.3)
Авлага	5,845,942.7	5,776,719.9	(69,222.8)
Бараа материал	4,417,731.2	4,257,717.8	(160,013.4)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	5,529,320.1	431,323.8	(5,097,996.3)
Үндсэн хөрөнгө	11,489,340.1	16,148,013.5	4,658,673.4
Нийт хөрөнгө	37,029,636.3	35,557,341.8	(1,472,294.5)
Өр төлбөр	11,404,970.8	9,702,632.3	(1,702,338.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	25,624,665.5	25,854,709.5	230,044.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	37,029,636.3	35,557,341.8	(1,472,294.5)

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, тооцоо, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн зэрэг данстууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,943.6 сая төгрөг болж, 803.7 сая төгрөгөөр буурсан нь хэвлэлийн буцаалтын өглөг, олон улсын транзит шуудангийн төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс кассад 5.2 сая төгрөг, арилжааны банкнуудын харилцах, хадгаламжийн дансанд 8,938.4 сая төгрөг байршуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 5,776.7 сая төгрөг болж, 69.2 сая төгрөгөөр буурсан нь гадаад валютын ханшийн тэгшитгэл хийснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,257.7 сая төгрөг болж, 160.0 сая төгрөгөөр буурахад үнэт цаас, марк, худалдан борлуулах гэрээт барааны борлуулалт бурсантай холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 431.3 сая төгрөг болж, 5,098.0 сая төгрөгөөр буурсан нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дээр баригдсан ялган боловсруулах барилгыг хүлээн авч, үндсэн хөрөнгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,148.0 сая төгрөг болж, 4,658.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Томо бьюлдинг ХХК-иар гүйцэтгүүлсэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах, Улс хоорондын ялган боловсруулах төвийн барилгыг 4,310.0 сая төгрөгөөр орлогод авч, 382.0 сая төгрөгийн салбар хоорондын шуудан хүргэлтийн автомашин, 120.8 сая төгрөгөөр ажилчдын автомашин, 39.0 сая төгрөгийн сэрээт өргөгч, 19.7 сая төгрөгийн камер, 68.6 сая төгрөгийн тавилга зэрэг нийт 814.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авснаас голлон шалтгаалсан байна. Мөн ТУЗ-ийн 2025 оны 25/18 дугаар тогтоолоор 3 ширхэг, 13.7 сая төгрөгийн барилга, 31 нэр төрлийн 110 ширхэг 793.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 8 нэрийн 8 ширхэг 90.2 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 208 нэр төрлийн 475 ширхэг тавилга, эд хогшил, 223 нэр төрлийн 719 ширхэг 781.8 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 5 нэр төрлийн 17 ширхэг 684.5 мянган төгрөгийн программ, лиценз, нийт 2,494.8 сая төгрөгийн 1,330 ширхэг хөрөнгийг акталж, 2,524.9 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Дээрх үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 1,557.1 сая төгрөгийн үнэ бүхий 16 программ хангамжтай бүртгэлтэй байна. Тайлант онд байгууллагад ашиглагдаж байгаа Интерактив ХХК-ийн хүний нөөц, санхүүгийн цогц программын хөгжүүлэлт, засвар үйлчилгээнд 4.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 9,702.6 сая төгрөг болж, 1,702.3 сая төгрөгөөр буурсан нь гадаадын байгууллагад төлөх транзит шуудангийн төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 25,854.7 сая төгрөг болж, 230.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн ашиг, гадаад валютаарх дансны үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэл голлох нөлөө үзүүлсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн гүйцэтгэх захирал нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулан ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол шуудан ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 24/20 дугаар тогтоолоор тус компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт орлогыг 27,790.0 сая төгрөг, нийт зардлыг 27,267.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтыг 5,935.6 сая төгрөг, татвар төлөхийн өмнөх ашгийг 522.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 26,570.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 26,050.9 сая төгрөгийн зардал гарган, 473.8 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 26,570.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,219.5 сая төгрөг буюу 4.4 хувиар дутуу биелсэн нь транзит шуудангийн орлого 1,616.0 сая төгрөгөөр дутуу биелснээс голлон шалтгаалжээ.

Гадаад шуудангийн үйлчилгээний орлогоос 8,122.3 сая төгрөгийг бүрдүүлж, орлого 4,377.7 сая төгрөгөөр тасарсан нь АНУ-тай буухиа шуудангийн солилцоо хийгдэхгүй болсноос шалтгаалсан байна.

Дотоод шуудан үйлчилгээний орлогоос 12,464.3 сая төгрөг, бусад нэмэлт үйлчилгээний орлогоос 1,724.3 сая төгрөг, санхүүгийн үйл ажиллагаанаас 2,223.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь төлөвлөснөөс 3,158.2 сая төгрөгөөр давуулан биелжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 26,050.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,216.6 сая төгрөг буюу 4.5 хувиар дутуу зарцуулалттай байгаа нь хүний нөөцийн зардлыг 10.7 сая төгрөг, тээвэр шатахууны зардлыг 973.1 сая төгрөг, хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлыг 90.3 сая төгрөг, үйл ажиллагааны бусад зардлыг 106.6 сая төгрөг, үйл ажиллагааны бус бусад зардлыг 35.9 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулснаас голлон нөлөөлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 24/22 дугаар тогтоолоор компанийн бүтэц, зохион байгуулалт болон орон тооны дээд хязгаарыг шинэчлэн 980 албан хаагчтай байхаар баталж, гүйцэтгэлээр нийт 970 ажилтны орон тоотой ажилласан байна.
- Монгол шуудан ХК нь хоолны хөнгөлөлт олгодоггүй, салбарын шууданч нар маршрутын дагуу хүргэлт хийх зориулалтаар унааны хөнгөлөлт авдаг бөгөөд тайлант хугацаанд унааны зардалд 19.8 сая төгрөг төсөвлөж, гүйцэтгэлээр 19.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Тайлант хугацаанд 25 арга хэмжээний хүрээнд 200.0 сая төгрөгийн гадаад томилолын зардал төсөвлөж, гүйцэтгэлээр 22 арга хэмжээнд 196.4 сая төгрөгийг зарцуулсан;

- Тус компани 2025 оны 6 дугаар сард Ази номхон далайн шуудангийн холбооны бүсийн 32 орны 100 гаруй төлөөлөгчтэй, “Удирдах зөвлөлийн хурал”-ыг зохион байгуулж 140.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.5.2 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол шуудан ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 24/20 дугаар тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 4,161.0 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 1,011.7 сая төгрөг, харьцуулалтын аргаар 561.8 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 528.9 сая төгрөг, нийт 2,102.4 сая төгрөгийн худалдан авалтыг хийжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналтыг сайжруулах, банк болон ББСБ-уудад байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, хуримтлуулж тооцсон хадгаламжийн хүүг хагас жил тутам тооцож байх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Баянжаргал, аудитор Д.Мэндбаяр нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Тэгшсүрэн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 03/146 дугаар албан бичгээр, хуулийн хугацааг 14 хоног хоцроож ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 24,226.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 242.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант хугацаанд түрээсийн зардлыг 133.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 146.6 сая төгрөг, зар сурталчилгааны зардлыг 108.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хамаарал бүхий 33 заалтыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 16 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих нийт 142,784.8 сая төгрөгийн 156 мэдээлэл байршуулахаас, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 156 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт.1 Монгол шуудан ХК нь "Омни капитал ББСБ" ХХК-тай сонгон шалгаруулалт хийлгүүгээр шууд гэрээ байгуулж 500.0 сая төгрөгийг жилийн 16 хувийн хүүтэйгээр хадгалуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.”, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн менежментийг оновчтой зохион байгуулж, холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт.2 Компани нь том 5 хувьцаа эзэмшигчийн нэг болох Ард кредит ББСБ ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ХИУГ/2045 дугаартай гэрээ байгуулж, 1.0 сая ам.долларыг 6 сарын хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэй хадгалуулсан. Ард кредит ББСБ нь тус хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдөр мөнгийг буцааж шилжүүлээгүй, 10 дугаар сарын 1-ний өдрөөс дахин 6 сараар сунгасан нь эргэн төлөгдөхөд эрсдэл учирч болзошгүй байна.

Энэ нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.6-д “Хадгаламжийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хугацаатай хадгаламжийн гэрээний хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсхүл гэрээг дахин сунгуулах хүсэлт тавиагүй бол хадгалагч дараах арга хэмжээг авна”, 12.6.2-т “хуулийн этгээд болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдийн хадгаламжийн дансыг гэрээнд заасан харилцах дансанд шилжүүлэх”, Ард кредит ББСБ ХХК-тай байгуулсан ХИУГ/2045 дугаартай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т “гэрээний 3.1-д заасан хугацааны эцэст итгэлцлийн дүнг хуримтлагдсан үр шимийн хамт гэрээний 3.8-д заасан итгэмжлэгчийн хөрөнгө хүлээн авах дансанд шилжүүлнэ. Гадаад валютын хувьд ББСБ-д анх оруулсан хэлбэрээс шалтгаалан валютын дүнгээр эсвэл тухайн өдрийн ХХБ-ны валютын бэлэн бус авах ханшаар тооцож төгрөгт хөрвүүлсэн дүнгээр гэрээний 3.8-д заасан дансанд шилжүүлнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид банк болон ББСБ-уудын нөхцөлийг харьцуулсан судалгаа хийж, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу явуулж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт.3 Компанийн санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаа 14 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 10 дугаар зүйлийн 10.3-т “энэ хуулийн 4.1.1-т заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.” Заалтууд болон санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлээгүй буруутай ажилтанд хуульд заасны дагуу сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд илэрсэн асуудал нь холбогдох эрх зүйн шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, татварын бүртгэл, цалин хөлстэй холбоотой дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 78.2 сая төгрөгийн зөрчилд 41.2 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 37.0 сая төгрөгийн 3 зөрчлийг жилийн эцсийн аудитын дүнд нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тогтоосон нийт 73.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 14.9 сая төгрөгийн зөрчилд тогтоосон 3 төлбөрийн акт, 12.7 сая төгрөгийн зөрчилд хүргүүлсэн 3 албан шаардлага, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 45.9 сая төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 74.3 хувьтай биелсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	14,940.1	3	14,940.1	100.0
Албан шаардлага	3	12,735.1	2	8,914.6	70.0
Зөвлөмж	5	45,931.1	5	35,826.3	78.0
Нийт дүн	11	73,606.3	10	59,681.0	82.7

Өмнөх аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлтэй холбоотой асуудлыг тайлант онд хэрэгжүүлээгүй, давтан гаргасан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулж аудитын горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Монгол шуудан ХК-д Төв аймгийн Сэргэлэн сум, Хөшгийн хөндийд хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөөр баригдсан жилдээ 3.0 сая илгээмж ялган боловсруулах хүчин чадалтай “Олон улсын шуудангийн илгээмж, ангилан ялгах, гаалийн хяналтад оруулах цогцолбор төв”-ийн 5,358.2 сая төгрөгийн өртөг бүхий 2 давхар барилгын газрыг Зам тээврийн яамнаас 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “нөхөн төлбөргүйгээр газрыг чөлөөлөх тухай” 03/3346 дугаар мэдэгдэл, НУБИА ХХК-иас “Ус дулааныг зогсоох тухай” 2025 оны EG-OA/176 дугаар албан бичиг ирж, 8 дугаар сарын 31-ний өдрөөс ус дулааны хэрэглээг хязгаарласан асуудлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд үүсгэсэн нэхэмжлэлтэй холбоотой асуудал компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн эсэх;
- Мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эрсдэл багатай, банк санхүүгийн байгууллагад байршуулсан, үлдэгдлийг хагас жил тутамд тооцоо нийлж баталгаажуулсан эсэх;
- Монгол шуудан ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 25/19 дүгээр тогтоолоор 408.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 14 тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг зохион байгуулж, орлогыг бүрэн хүлээн авсан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82.9 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Компани нь арилжааны 2 банк, 2 ББСБ-дад нийт 2.1 сая америк доллар, 0.5 сая төгрөгийн хадгаламж байршуулсан. Дээрх хадгаламжуудын хүүг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаар тооцож 79.9 сая төгрөгийг хадгаламжийн хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй, хадгаламжийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөгийг 3.1 сая төгрөгөөр илүү төлөлт хийж, авлагаар бүртгээгүй.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 789.1 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 3.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 36.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага, 749.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага тус тус хүргүүлж, мөнгөн хадгаламжийн гэрээ, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 789.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 546.8 сая төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт.1: Ард кредит ББСБ-д байршуулсан 1.0 сая ам.долларын хадгаламжийн гэрээний хугацаа 9 дүгээр сарын 27-нд дуусаж 10 дугаар сарын 01-ний өдрөөс 6 сарын хугацаатай сунгасан боловч 4 хоногийн 444.44 ам.доллар буюу 1.6 сая төгрөгийг хадгаламжийн хүүг тооцон нэхэмжилж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтын 10-т "Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", 70 дугаар зүйлийн 7-д "банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг авах бүрдээ дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг батлах.",

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүний төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

71 дүгээр зүйлийн 1/8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.” гэж тус тус заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдрөөс хойш 4 хоногийн хадгаламжийн хүүг тооцож нэхэмжлээгүй 1.6 сая төгрөгийг буруутай ажилтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт.2: Компани нь 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Монгол шуудан банкны нэр дээр жилийн 8 хувийн хүүтэй "CPA-TOWER" бондыг 0.5 сая төгрөгөөр худалдан авч, хөрөнгө оруулалтаар бүртгэсэн, Монгол шуудан банктай ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулаагүй, өнөөдрийг хүртэлх хугацааны 1.2 сая төгрөгийн бондын хүү тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 1/8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол шуудан ХК нь Монгол шуудан банктай зохих гэрээ, хэлцэлгүйгээр 0.5 сая төгрөгийн бонд худалдан авсан, бондын хүү тооцож аваагүй 1.2 сая төгрөгийг буруутай албан тушаалтанаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага:

Илрүүлэлт.1: Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны ертгөө нөхсөн 6 нэр төрлийн 69 ширхэг нийт 36.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн чанар байдлыг тооллогын комисс бүрэн тодорхойлоогүй, актлах, дахин үнэлэх асуудлыг ТУЗ-д хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.” гэсэн тус тус заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар албан шаардагыг хэрэгжүүлж ажиллаагүй, хөрөнгийн тооллогын үр дүнг бодитоор үнэлээгүй, хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Албан шаардлага

Илрүүлэлт.1: Компанийн нийт авлагын 70.6 хувь буюу 3,815.1 сая төгрөг нь улс хоорондын тооцооны авлага байна. Үүнээс 47 харилцагчийн 442.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт.2: Тус компани нь гадаадын 73 байгууллага, дотоодын 35 аж ахуйн нэгж, иргэнд өгөх нийт 238.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт.3: Олон жилийн насжилттай, 2017-2020 онуудад үүссэн 17 аж ахуйн нэгж, 10 иргэнээс авах нийт 67.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар авах арга хэмжээг эрчимжүүлж 30 хувиар бууруулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлэх.Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Компани нь арилжааны 2 банк, 2 ББСБ-д нийт 2.1 сая ам. доллар, 0.5 сая төгрөгийн хадгаламж байршуулсан. Дээрх хадгаламжуудын хүүг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаагаар тооцож 79.9 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй, хадгаламжийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	79,853.3	1	79,853.3			1	79,853.3				
Бэлтгэн нийлүүлэгчийн өглөгийг 3.1 сая төгрөгөөр илүү төлөлт хийж, авлагаар бүртгээгүй.	1	3,062.5			1	3,062.5	1	3,062.5				
Дүн	2	82,915.8	1	79,853.3	1	3,062.5	2	82,915.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ард кредит ББСБ-д байршуулсан 1.0 сая ам.долларын хадгаламжийн гэрээний хугацаа 9 дүгээр сарын 27-нд дууссан боловч мөнгийг буцаан татаж авалгүйгээр, 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 сараар гэрээний хугацааг сунгасан. Хугацаа сунгах хүртэлх 4 хоногийн хадгаламжийн хүү 444.44 ам. доллар буюу 1.6 сая төгрөгийг нэхэмжилж аваагүй байна.	1	1,580.7	1	1,580.7								

Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Компанийн нийт авлагын 70.6 хувь буюу 3,815.1 сая төгрөг нь улс хоорондын тооцооны авлага байна. Үүнээс 47 харилцагчийн 442.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	442,864.8			1	442,864.8					
Тус компани нь гадаадын 73 байгууллага, дотоодын 35 аж ахуйн нэгж, иргэнд өгөх нийт 238.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	238,363.4			1	238,363.4					
Компани нь 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Монгол шуудан банкны нэр дээр жилийн 8 хувийн хүүтэй "CPA-TOWER" бондыг 0.5 сая төгрөгөөр худалдан авч, хөрөнгө оруулалтаар бүртгэсэн, МШБанктай ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулаагүй, өнөөдрийг хүртэлх хугацааны 1.2 сая төгрөгийн бондын хүү тооцоогүй байна.	1	1,696.6	1	1,696.6							
Компанийн санхүүгийн тайланд олон жилийн насжилттай, 2017-2020 онуудад үүссэн, 17 аж ахуйн нэгж байгууллага, 10 иргэнээс авах нийт 67.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	67,783.1			1	67,783.1					
Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 69 ширхэг нийт 36.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн чанар байдлыг тооллогын комисс бүрэн тодорхойлоогүй, актлах, дахин үнэлэх асуудлыг ТУЗ-д хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	36,836.0						1	36,836.0		
Дүн	6	826,124.6	2	3,277.3	3	786,011.3			1	36,836.0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
1	Компанийн санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаа 14 хоног хоцроож ирүүлсэн байна.	1	-					1	-		
2	Монгол шуудан ХК нь "Омни капитал ББСБ" ХХК-тай сонгон шалгаруулалт хийлгүйгээр шууд гэрээ байгуулж 500.0 сая төгрөгийг жилийн 16 хувийн хүүтэйгээр хадгалуулсан байна.	1	-							1	-
3	Компани нь том 5 хувьцаа эзэмшигчийн нэг болох Ард кредит ББСБ ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ХИУГ/2045 дугаартай гэрээ байгуулж, 1.0 сая ам.долларыг 6 сарын хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэй хадгалуулсан. Ард кредит ББСБ нь тус хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдөр мөнгийг буцааж шилжүүлээгүй, 10 дугаар сарын 1-ний өдрөөс дахин 6 сараар сунгасан нь эргэн төлөгдөхөд эрсдэл учирч болзошгүй байна.	1	-							1	-
	Дүн	3	-					1	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 146/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/48/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компани нь 2008 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Монгол шуудан банкны нэр дээр жилийн 8 хувийн хүүтэй "CPA-TOWER" бондыг 500,000.00 /таван зуун мянган/ төгрөгөөр худалдан авч, хөрөнгө оруулалтаар бүртгэсэн, Монгол шуудан банктай ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулаагүй, өнөөдрийг хүртэлх хугацаанд 1,196,555.00 /нэг сая нэг зуун ерэн зургаан мянга таван зуун тавин таван/ төгрөгийн бондын хүү тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил өүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 1/8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн."-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол шуудан ХК нь Монгол шуудан банктай зохих гэрээ, хэлцэлгүйгээр 500,000.00 /таван зуун мянган/ төгрөгийн бонд худалдан авсан, бондын хүү тооцож аваагүй 1,196,555.00 /нэг сая нэг зуун ерэн зургаан мянга таван зуун тавин таван/ төгрөгийг Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитор /Г.Ганчимэг/ нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол шуудан ХК-ийн Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/-д, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд (ТУЗ)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бяга тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Акт 2026\0316\САГ-12\Доxx

1526000162



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 147/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/48/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ард кредит ББСБ-д байршуулсан 1.0 сая ам.долларын хадгаламжийн гэрээний хугацаа 9 дүгээр сарын 27-нд дуусаж 10 дугаар сарын 01-ний өдрөөс 6 сарын хугацаатай сунгасан боловч 4 хоногийн 444.44 ам.доллар буюу 1,580,737.78 /нэг сая таван зуун наян мянга долоон зуун гучин долоон төгрөг, далан найман мөнгө/ төгрөгийн хадгаламжийн хүүг тооцон нэхэмжлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1/10-т "Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", 70 дугаар зүйлийн 7-д "Банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг авах бүрдээ дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг батлах", 71 дүгээр зүйлийн 1/8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн."-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол шуудан ХК нь хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдрөөс хойш 4 хоногийн хадгаламжийн хүүг тооцож нэхэмжлээгүй 1,580,737.78 /нэг сая таван зуун наян мянга долоон зуун гучин долоон төгрөг, далан найман мөнгө/ төгрөгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитор /Г.Ганчимэг/, хяналт хэрэгжүүлж ажиллаагүй Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/ нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол шуудан ХК-ийн Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Ar-2026\0316\SAG-12.Docx

152600160



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 643/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/48/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 69 ширхэг нийт 36,836,011.39 /гучин зургаан сая найман зуун гучин зургаан мянга арван нэгэн төгрөг, гучин есөн мөнгө/ төгрөгийн тоног төхөөрөмжийн чанар байдлыг тооллогын комисс бүрэн тодорхойлоогүй, актлах, дахин үнэлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ;" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол шуудан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитор /Г.Ганчимэг/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 644/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/48/НА - СТА -ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, санхүүгийн тайланг хуулийн хугацаа 14 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуулийн 4.1.1-т заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ." заалтууд болон санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ;" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол шуудан ХК-ийн Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 640/АД/50061

Улаанбаатар хот

САГ - 2026/48/НА - СТА - ТВҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн нийт авлагын 70.6 хувь буюу 3,815,127,318.52 /гурван тэрбум найман зуун арван таван сая нэг зуун хорин долоон мянга гурван зуун арван найман төгрөг, тавин хоёр мөнгө/ төгрөг нь улс хоорондын тооцооны авлага байна. Үүнээс 47 харилцагчийн 442,864,778.70 /дөрвөн зуун дөчин хоёр сая найман зуун жаран дөрвөн мянга долоон зуун далан найман төгрөг, далан мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 641/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/48/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь гадаадын 73 байгууллага, дотоодын 35 аж ахуйн нэгж, иргэнд өгөх нийт 238,363,423.87 /хоёр зуун гучин найман сая гурван зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорин гурван төгрөг, наян долоон мөнгө/ төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 642/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/48/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол шуудан ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон жилийн насжилттай, 2017-2020 онуудад үүссэн 17 аж ахуйн нэгж, 10 иргэнээс авах нийт 67,783,117.38 /жаран долоон сая долоон зуун наян гурван мянга нэг зуун арван долоон төгрөг, гучин найман мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар авах арга хэмжээг эрчимжүүлж 30 хувиар бууруулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газартирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол шуудан ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Тэлмэн/, Санхүү, төлөвлөлтийн газрын захирал /Б.Нарандулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Д.ЭНХБААТАР